# БАГАНУУР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 08

Багануур дүүрэг

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| НЭГ.МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2010 ОНЫ 53 ДУГААР ЗАРЛИГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД; | | | | | | | |
| Зорилт1.Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгын хүрээнд: | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлэх. | Байгууллагын төсөв | Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт /насны ангиллаар/ сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлж хувиар тогтооно. | 2024 онд ББТТСорилд хүн 10127 хамрагдсан. Үүнээс:<br><br>А-2467<br>В-2805<br>С-2724<br>А,В,С үнэлгээ авсан хүний эзлэх хувь 78,9-тай. | 2025 онд сорилд хамрагдсан нийт иргэдийн А ,В, С үнэлгээтэй хүний тоог 60%-д хүргэнэ. | Дүүргийн байгууллагуудын арга зүйч, спорт хамтлагийн гишүүдэд бие бялдрын түвшин тогтоох сорилын онол практик болон Спортын бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 40 байгууллагын 50 албан хаагчдын дунд зохион байгуулсан. Тус сургалтын хүрээнд арга зүйч, спорт хамтлагийн гишүүд байгууллагын ажилтан, албан хаагчдаас сорил авах чиглэл хүргүүлж, 7327 иргэнээс сорил авч А,1519,- В,1979- 2155-үнэлгээ авсан хүний эзлэх хувь 77,1 байна. | 100 |
| Зорилт 2.Спортын хамтлаг, клубын тогтолцоог нэвтрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалах зорилгын хүрээнд: | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1<br>Биеийн тамир, спорт хамтлагийн арга зүйчдийн дунд биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллана. | | Төлөвлөсөн ажлын тоо, хэрэгжилтийн хувиар | 2024 онд 8 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Хэрэгжилт- 91 хувьтай. | Төлөвлөгөөнд 12 ажил тусган батлуулж, биелэлтийг хангаж ажиллана. | Биеийн тамир, спорт хамтлагийн арга зүйчдийн дунд биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөөг 12 заалттайгаар хэрэгжүүлэн ажилласан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө гарган ажиллана. | | | хувьтай. | ажиллана. | | |
| 3. | Арга хэмжээ 2.2<br>Биеийн тамир, спорт хамтлагийн арга зүйчдийн судалгааг шинэчлэн гаргана. | | Шинэчлэн гаргах судалгааны тоо | Судалгааг 1 удаа шинэчлэн гаргасан. | 1 удаа | Аж ахуйн нэгжүүдийн биеийн тамир спорт хамтлагийн судалгааг шинэчилсэн. Дүүрэгт 33 байгууллагад 33 спорт хамтлаг үйл ажиллагаагаа явуулж байна. | 100 |
| 4. | Арга хэмжээ 2.3<br>Биеийн тамир, спорт хамтлагийн арга зүйчдийн нэгдсэн уулзалтыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгнө. | Байгууллагын төсөв 909,200 | Зохион байгуулах сургалтын тоо, хамрагдах албан хаагчдын тоо | 1 уулзалт зохион байгуулж, 40 арга зүйч хамрагдсан. | 1 уулзалт<br>40 арга зүйч | Дүүргийн байгууллагуудын арга зүйч, спорт хамтлагийн бие бялдрын түвшин тогтоох сорилын онол практик болон спортын бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж, 40 байгууллагын 50 албан хаагчийг хамруулсан. | 100 |
| 5. | Арга хэмжээ 2.4<br>Биеийн тамир, спорт хамтлагийн арга зүйчдийн дунд бие бялдрын түвшин тогтоох сорил авах аргачлалын тэмцээн зохион байгуулна. | Байгууллагын төсөв | Хамрагдах албан хаагчдын тоо | - | 40 арга зүйчийг хамруулна. | Хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорил авах аргачлалаар 40 байгууллагын 50 арга зүйч 7 багт хуваан хүчний чанарыг тодорхойлох арга, тэнцвэрийн чанарыг тодорхойлох арга, тэсвэрийн чанарыг тодорхойлох гэсэн чанаруудаар тэмцээн зохион байгуулсан. | 100 |
| 6. | Арга хэмжээ 2.5<br>Бие бялдрын түвшин тогтоох сорилын сургалт зохион байгуулна. | Байгууллагын төсөв | Хамрагдах албан хаагчдын тоо | 22 арга зүйчийг хамруулсан. | 40 арга зүйчийг хамруулна. | Байгууллага аж ахуйн нэгжийн арга зүйч, спорт хамтлагийн ахлагч нарт бие бялдрын түвшин тогтоох сорилын онол практикийн сургалтыг 40 байгууллагын 50 хүн хамрагдсан. Сургалтыг БТСУХ-ны НБТ-ын асуудал хариуцсан зөвлөх профессор, докторОУХМ Ж.Тунгалаг, БТСУХорооны БТ-ын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Гантөмөр,” Багануур“ ХК-ны Бага эмч, хөдөлгөөн засалч О.Даринчулуун мөн БТСХорооны Биеийн тамирын хэлтсийн дарга, мэргэжилтэн нар зохион байгуулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 2.6 Шилдэг биеийн тамир, спорт хамтлагийг шалгаруулна. | 2.3 сая | Хамруулах спорт хамтлагийн тоо | 22 | 30 | 33 аж ахуйн нэгж байгууллагын спорт хамтлагийн 2025 оны жилийн эцсийн тайланг хүлээн авч шилдэг спорт хамтлагийг шалгаруулав. | 100 |
| ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД: | | | | | | | |
| Зорилт 3.Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгуулллагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах | | | | | | | |
| 8. | Арга хэмжээ 3.1 Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах. | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээгээр | 2024 оны хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж хувь 87,8 хувьтай хэрэгжсэн. | Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг үнэлгээгээр гаргаж дээд газарт хүргүүлнэ. /Цахимаар/ | Биеийн тамир спортын тухай хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд МУИХ, МУЗГ, Нийслэл болон дүүргээс гарч буй биеийн тамир спортын чиглэлийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж хувь 95,8 хувьтай хэрэгжсэн. | 100 |
| 9. | Арга хэмжээ 3.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтэд, тайлагналтын үйл ажиллагааг хууль журамд заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх | | Хүргүүлэх төлөвлөгөө, тайлангийн тоо | 2 | 2 | 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Дүүргийн Засаг дарга болон Биеийн тамир, спортын Улсын хорооны даргаар хянан батлуулж хууль журамд заасан хугацаанд тайланг дүүргийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн биеийн тамир спортын газар болон БТСУХороонд хүргүүлсэн. | 100 |
| 10. | Арга хэмжээ 3.3 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулах | | -Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, сургалтад хамрагдсан тоо | Хэрэгжилтийн хувь - 90 21 сургалт | -Хөтөлбөрийн хэрэгжилтийг 90-с доошгүй хувиар биелүүлж, 18 сургалтад хамрагдсан байна. | Нийт 32 сургалт зохион байгуулагдсан. Үүнд: ажлын байранд буюу дотоод сургалт -15, мэргэшүүлэх-9, гадаад сургалтад-1, бусад- 7 сургалт | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11. | Арга хэмжээ 3.4 Байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, зөвлөмж, дүгнэлт гаргах | | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх давтамж | 2 удаа | 2 удаа | Байгууллагын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/42 дугаар тушаалаар байгууллагын дотоод хяналтын нэгжийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж төлөвлөгөө гарган батлуулсан.Дотоод хяналт шалгалтыг холбогдох журам төлөвлөгөөний дагуу 3 удаа хийж гүйцэтгээд байна. Байгууллагын бодлогын баримт бичигт (байгууллагын гүйцэтгэлийн төвлөвлөгөө, хөтөлбөрүүдэд) хяналт шинжилгээ, үнэлгээг 2 удаа хийж албан хаагчдад тухай бүр нь зөвлөн тусалж зөвлөмж, дүгнэлт өгч ажилласан. | 100 |
| Зорилт 4.Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлэх *(АХ-2050-3.5, МУХТЖҮЧ-3.5, НХТЖҮЧ-3.5)* | | | | | | | |
| 12. | Арга хэмжээ 4.1. “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хамтдаа гүйцгээе” аяныг зохион байгуулна. | Байгууллагын төсөв 600,000 | Хамрагдах байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тоо | - | 42 байгууллага, аж ахуйн нэгж, 1000 иргэд хамрагдана. | “Эрүүл Монгол хүн” хөдөлгөөний хүрээнд зохион байгуулж байгаа “Хамтдаа гүйцгээе” аян 2025 оны 01 дүгээр сарын 20-ноос 04 дүгээр сарын 20-ны хооронд нийт 61 байгууллагын 1800 иргэд хамрагдсан. | 100 |
| 13. | Арга хэмжээ 4.2. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг зохион байгуулна. | | Аянд хамрагдах иргэдийн тоо | 4500 | 4500 | Аянг 2025 оны 01 дүгээр сарын 20-ноос 04 дүгээр 20-ны хооронд зохион байгуулж нийт 2000 иргэд хамрагдсан. | 44,4 |
| 14. | Арга хэмжээ 4.3. “Алхацгаая гүйцгээе” аяныг зохион байгуулна. | | Аянд хамрагдах иргэдийн тоо | 4500 | 4500 | “Монголын явган алхалтын холбоо” ТББ-тай хамтран дүүргийн ажил, амьдрал ахуй, байгаль орчин, түүх дурсгалтай танилцах “Хамтдаа алхцгаая” хүн бүр байгаль хамгаалагч” уриатай “Миний нутаг Багануур” эрүүл мэндийн алхалтын 6 аймаг, 3 дүүргийн 110 гаруй алхагчдыг хамруулан зохион байгууллаа. “Алхацгаая, гүйцгээе” аянд 2000 иргэн хамрагдсан. | 47 |
| ГУРАВ.ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД: | | | | | | | |
| Зорилт 5.Үндэсний болон спортын төрлүүдийг хөгжүүлж,тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.*(АХ-2050-3.5.12, МУХТЖҮЧ-3.5.3,НХТЖҮЧ-3.5.4,* | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| *НЗДҮАХ-2.1.8)* | | | | | | | |
| 15. | Арга хэмжээ 5.1. Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн-эрүүл мэнд” биеийн тамир, спортын IX их наадмыг зохион байгуулна. | Дүүргийн төсөв 35.0 сая | Зохион байгуулах үйл ажиллагааны төрөл, хамрагдах хүний тоо | 12<br>2300 | 12<br>2291 | Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн-эрүүл мэнд” биеийн тамир, спортын IX их наадмыг спортын 12 төрлөөр зохион байгуулж, 85 байгууллага, аж ахуйн нэгжийн 16 багийн 2306 тамирчин оролцож шилдгүүдийг шалгаруулан шагнаж урамшуулсан. | 100 |
| 16. | Арга хэмжээ 5.2. Монголын хүүхдийн спортын VIII наадмын шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | Дүүргийн төсөв 12,0 | Зохион байгуулах тэмцээний төрөл, хамрагдах иргэдийн тоо | 10<br>512 | 11<br>600 | Монголын хүүхдийн спортын VIII наадмын Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 12 төрлөөр зохион байгуулж дүүргийн 5 сургуулийн 609 сурагчид, тамирчид оролцож шилдгүүдийг шалгаруулсан. | 100 |
| | | Дүүргийн төсөв 18,0 сая 1,3-БТСХ | Зохион байгуулах шигшээ тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо | 12<br>127 | 12<br>130 | Монголын хүүхдийн спортын VIII наадмын шигшээ тэмцээний өвлийн спортын төрөлд шайбтай хоккейн 2 насны ангиллалд 2 баг тэргүүн байр эзэлж алтан медаль, зуны спортын төрлийн тэмцээнүүдэд спортын 16 төрлөөр 137 тамирчид, 12 дасгалжуулагч оролцож сагсан бөмбөгийн хөвгүүдийн баг хүрэл медаль, жу-до бөхийн төрөлд 2 хүрэл медаль, чөлөөт бөхийн төрөлд 2 хүрэл медаль нийт алтан медаль-2, хүрэл медаль-5, бүгд- 7 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | 100 |
| 17. | Арга хэмжээ 5.3. Монголын Бүх ард түмний спортын зуны наадмын бүсийн болон шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ.<br>. | Дүүргийн төсөв 18,0 сая | Зуны шигшээ тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо | 13<br>86 | 27<br>286 | Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 12 төрлөөр 16 багийн давхардсан тоогоор 1872 тамирчин, шигшээ тэмцээнд 13 төрлөөр 78 тамирчин, 5 дасгалжуулагч оролцож, сагсан бөмбөгийн төрөлд эмэгтэй баг хүрэл, таеквондогийн төрөлд 67 кг жинд хүрэл, Бочи спортын төрөлд мөнгө, хүрэл, Пауэрлифтингийн 57 кг жинд түлхэлтээр алтан медаль, дэд мастерын болзлыг 2 хүн хангасан амжилтыг үзүүлсэн. | 96,2 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18. | Арга хэмжээ 5.4. Нийслэлийн Иргэдийн спортын наадмыг зохион байгуулж, шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | | Зохион байгуулах дүүргийн тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо | 7<br>364 | 9<br>524 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу НБТСГ-аас тус тэмцээн зохион байгуулагдаагүй болно. | 0 |
| | | | Зохион байгуулах шигшээ тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо | 8<br>114 | 9<br>136 | Тус тэмцээн нийслэлд зохион байгуулагдаагүй учир дүүрэгт зохион байгуулаагүй болно. | |
| 19. | Арга хэмжээ 5.5. "Улаанбаатар лиг" өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | Дүүргийн төсөв 10,0 сая<br>сая 4,2-БТСХ | Зохион байгуулах тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо | 2<br>468 | 2<br>660 | Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг сагсан бөмбөг, волейболын төрлөөр зохион байгуулж, нийт 62 багийн 744 тамирчид оролцсон бөгөөд "Улаанбаатар лиг" нийслэлийн аварга шалгаруулах шигшээ тэмцээний сагсан бөмбөгийн тэмцээнд 2 насны ангиллаар 4 баг, волейболын тэмцээнд 3 насны ангиллаар 6 багийн нийт 122 тамирчин тус тус оролцож, мөнгөн 1, хүрэл 2 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | 100 |
| 20. | Арга хэмжээ 5.6. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлж, баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | Дүүргийн төсөв<br>15сая 0, | Шигшээ багийн хичээллэх төрөл, тамирчдын тоо | 7<br>136 | 8<br>155 | Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ баг спортын 7 төрлөөр 199 тамирчин хичээллэж байна.Шигшээ багийн тамирчид болон шинээр хөгжүүлж буй тийбол спортын 2 багийн 30 тамирчинд бие халаалт болон тоглолтын хувцасны дэмжлэг үзүүлээд байна. | 90 |
| | | сая<br>сая 10,0-БТСХ<br>ивээн ,эцэг эх | Шигшээ тэмцээнд оролцох төрөл, давтамж | 7<br>35 тэмцээнд оролцоход 13,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн | 8<br>40 | Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн 7 шигшээ багийн тамирчид улс, олон улс, тив дэлхийн чанартай нийт 43 тэмцээнд оролцож, алт 27, мөнгө 28, хүрэл 26 медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлээд байна. | 96,8 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21. | Арга хэмжээ 5.7. U15 насны улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулна. | 10,0 сая | Тэмцээнд оролцох баг, тамирчдын тоо | 24<br>360 | 25<br>375 | Өсвөрийн сагсан бөмбөгийн U15 насны улсын аварга шалгаруулах тэмцээнийг дүүрэгт зохион байгуулж, тэмцээнд эрэгтэй 48, эмэгтэй 24, нийт 72 багийн 1100 гаруй өсвөрийн тамирчид оролцож, шилдгүүдийг шалгаруулсан. | 100 |
| 22. | Арга хэмжээ 5.8. U18 насны болон +40 насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах хоккейн тэмцээн зохион байгуулна. | Дүүргийн төсөв 8.0 сая | Хоккейн тэмцээнд оролцох баг, тамирчдын тоо | - | 10<br>200 | Монголын хоккейн холбоотой хамтран U18 насны болон +40 насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах хоккейн тэмцээнийг дүүрэгт зохион байгуулж 10 багийн 207 тамирчин оролцож, шилдгүүдийг шалгаруулсан. 20-40 жил шайбтай хоккейгоор хичээллэж, лигийн аваргаар 3-5 удаа шалгарч байсан 5 тамирчинд “спортын мастер” цол олгосон. | 100 |
| Зорилт 6.Иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлэн, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдалтыг нэмэгдүүлж, спортын холбоод, төрийн бус байгууллагуудыг дэмжиж, хамтын ажиллагааг сайжруулна. *(АХ-2050--3.5.3, НЗДҮАХ-2.1.7)* | | | | | | | |
| 23. | Арга хэмжээ 6.1. Олон улс, УАШТэмцээнд оролцож амжилт гаргасан баг, тамирчдыг шагнаж урамшуулах журмыг боловсруулан хэрэгжилтийг хангана. | Дүүргийн төсөв 155,7 сая | -Боловсруулж батлуулах журам<br>-Дэмжлэг үзүүлэх тамирчдын тоо | - | 1 журам боловсруулж, 15 тамирчинд дэмжлэг үзүүлнэ. | Дүүргийн Засаг даргын А/313 захирамжаар Дэлхий, Тив, Олон улс, Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлж, шагнаж урамшуулах журмыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсэг 4 удаа хуралдаж, журмын төслийг боловсруулан хэлэлцүүлэг зохион байгуулж, дүүргийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. Энэ жил Азийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 1 төрлөөр 5 тамирчинд, Олон Улсын тэмцээнд спортын 9 төрлөөр 180 тамирчинд, улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 35 төрлөөр 468 тамирчинд тус тус дэмжлэг үзүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 24. | Арга хэмжээ 6.2. Бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | Сорилд хамрагдах иргэдийн тоо | 6700 | 7000 | Дүүргийн байгууллагуудын арга зүйч, спорт хамтлагийн гишүүдэд бие бялдрын түвшин тогтоох сорилын онол практик болон спортын бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 40 байгууллагын 50 албан хаагчдын дунд зохион байгуулсан. Тус сургалтын хүрээнд арга зүйч, спорт хамтлагийн гишүүд байгууллагын ажилтан, албан хаагчдаас сорил авах чиглэл хүргүүлж, 7327 иргэнээс сорил авч А-1519, В-1979, С-2155 үнэлгээ авсан хүний эзлэх хувь 77.1 байна. | 100 |
| 25. | Арга хэмжээ 6.3. Спортын холбоод, төрийн бус байгууллагуудыг дэмжиж, хамтын ажиллагааг сайжруулна. | Дүүргийн төсөв 75,3 сая сая 11,5-БТСХ | Хамтран ажиллах спортын холбоод, ТББ-уудын тоо | 12 | 15 | Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 15 спортын холбоо, клуб, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, үндэсний бөх, үндэсний сур харваа, шагай харваа, шайбтай хоккей, сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, шатар, таеквондо, усанд сэлэлт, ширээний теннис, хүндийг өргөлт, пауэрлифтинг, чөлөөт бөх, жудо бөхийн төрлүүдэд дэмжлэг үзүүлээд байна. | 100 |
| 26. | Арга хэмжээ 6.4. Багийн спортын төрлийн тэмцээнийг лигийн журмаар зохион байгуулна. | Байгууллагын төсөв 3,0 | Зохион байгуулах багийн спортын төрөл | - | 2 | “Сурагчдын лиг” дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг сагсан бөмбөг, волейбол төрлөөр 02, 03 дугаар сард зохион байгуулж, нийт 28 багийн 336 тамирчид, сагсан бөмбөгийн “Багануур лиг” тэмцээнийг 1-4 дүгээр сард зохион байгуулж, 8 багийн 128 тамирчид тус тус оролцож, шилдгүүдийг шалгаруулсан. | 100 |
| Зорилт 7.Биеийн тамир, спортын байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулна. (*АХ-2050-3.5.5, МУХТЖҮЧ-3.5.2, НХТЖҮЧ-3.5.2, МАН-2.3.9, АН-10.6,)* | | | | | | | |
| 27. | Арга хэмжээ 7.1. Биеийн тамир, спортын хорооны гадна засвар, тохижилтийн ажлыг хийж гүйцэтгэнэ. | 619,8 сая | Биеийн тамир, спортын хорооны засвар, тохижилтийн ажлын гүйцэтгэл | 10% | 100% | Биеийн тамир, спорт хорооны гадна засвар тохижилтын ажлын гүйцэтгэгчээр “Шайнинг хаус” ХХК шалгарч бараа материалын татан авалт хийгдсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна. | 50 |
| Идэвхитэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгоно. | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 8.Хүн амын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ. | | | | | | | |
| 28. | Арга хэмжээ 8.1. “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, шигшээ гүйлтэд оролцуулна. | | Зохион байгуулах дүүргийн тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо | 120 | 120 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилт татагдсан тул тэмцээн зохион байгуулагдаагүй болно. | 0 |
| | | | Зохион байгуулах шигшээ тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо | 7 | 10 | ”Улаанбаатар марафон 2025“ олон улсын гүйлтэд дүүргээ төлөөлөн 25 тамирчин хамрагдсан. | 100 |
| 29. | Арга хэмжээ 8.2. Ахмад настнуудын дунд тэмцээн зохион байгуулна. | | Зохион байгуулах тэмцээний төрөл | 2 | 6 | Ахмадын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 6 төрлөөр 18 багийн 115 ахмад тамирчид оролцож 1,320,000 төгрөг зарцуулсан.<br>Улсын чанартай тэмцээнд ахмад тамирчид 2025 онд 10 төрлөөр 12 тэмцээнд 118 ахмадууд оролцож, алтан медаль-9, мөнгө медаль-5, хүрэл медаль-4, нийт-18 медаль хүртэж, 13,761,400 төгрөг зарцуулсан. | 100 |
| Зорилт 9. Хүн амын идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 30. | Арга хэмжээ 9.1. Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз платформ бий болгож хэрэгжүүлэх | | Цахим сангийн үндсэн цэсний мэдээллийг шинэчлэх, байршуулсан мэдээ, мэдээллийн тоо | Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллээс шилэн дансны 72, Хүний нөөцийн талаарх мэдээллийг | Цахимын үндсэн цэсний мэдээллүүдийг шинэчилж, 361 гаруй мэдээ, мэдээллийг цахим хуудсанд тавьж байршуулна | shilendans.gov.mn Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны болон бусад 148 мэдээлэл, Нээлттэй, ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээнд Shilen.gov.mn сайтад Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх-10, Хүний нөөцийн талаарх -7, Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх -10, Үзүүлж байгаа үйлчилгээний талаар -3 мэдээ нийт 21 мэдээлэл шинээр байршуулсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хуулийн хугацаанд байршуулсан. Цахим сангийн үндсэн цэсний 5 мэдээллийг шинэчилж, 4 цэс шинээр үүсгэв. bnd.sport.gov.mn site-д 40 мэдээлэл байршуулсан, Багануур Дүүргийн Спорт Хороо Facebook хуудсанд 86 мэдээлэл, 72 мэдээлэл хуваалцаж нийт 198 мэдээлэл байршуулсан. | | Shilen.gov.mn сайтад III улиралд байршуулсан мэдээллийн хүртээмжтэй, хугацаандаа нийтэлсэн, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал зэрэг 4 үзүүлэлтээр дүгнүүлэн 90.74 хувь үнэлэгддээ байна. https://bnd.sport.gov.mn/ web-д Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчлэсэн найруулга сурталчлах аянтай холбоотойгоор цахимд байршуулан сурталчлан ажилласан. Биеийн тамир спортын хорооны face хуудсанд 77 мэдээлэл, 9 урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээлэл, 16 зар, 148 спорттой холбогдолтой мэдээлэл хуваалцаж, 6 reel, ,БТСХ-ны youtube хуудсанд 2 контент нэвтрүүлэг оруулан ажилласан.Нийт 427 мэдээлэл байршуулаад байна. | 100 |
| 31. | Арга хэмжээ 9.2. Дүүрэгт спортын чиглэлээр үйл ажиллагаа чиглэлээр явуулж буй барилга, байгууламж, гадна талбайн судалгааг шинэчлэн гаргана. | | Шинэчлэн гаргасан судалгааны тоо | 2 | 2 | Судалгааг 2 удаа шинэчилж гаргасан бөгөөд 2025 оны байдлаар дүүрэгт спортын чиглэлээр нийт 12 заал үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд гадна талбай 24 байна. | 100 |
| 32. | Арга хэмжээ 9.3. Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэгчдийн тоон судалгааг гаргана. | | Судалгаа гаргасан тоо | 1 | 2 | Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэгчдийн тоон судалгааг 2 удаа авч, спортоор хичээллэх боломжоор хангаг долоо хоног бүрийн даваа, лхагва гаригт цаг гарган өгч, давхардсан тоогоор 2500 гаруй ахмадууд хичээллээд байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33. | Арга хэмжээ 9.4. Дүүргийн хэмжээнд хүүхэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэгчдийн судалгааг гаргана. | | Шинэчлэн гаргасан судалгааны тоо | 1 | 2 | Судалгааг 2 удаа гаргасан. Дүүргийн хэмжээнд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэд-1039 хүн байгаагаас эрэгтэй-500, эмэгтэй-420, үүнээс хүүхэд-119 буюу 11.4 хувийг эзэлж байна. эрэгтэй хүүхэд -85, эмэгтэй хүүхэд-34 байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 56.3 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бол 43.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Пара воллейболоор хичээллэх боломжтой 18-40 насны иргэд эрэгтэй-15, эмэгтэй-13 нийт 28 иргэд байна. | 100 |
| 34. | Арга хэмжээ 9.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд тэмцээн зохион байгуулна. | Байгууллагын төсөв | Зохион байгуулах тэмцээний төрөл, оролцох иргэдийн тоо | 7<br>110 | 8<br>120 | ХБИргэдийн дунд тэмцээнийг 02 дугаар сарын 10-аас 04 дүгээр сарын 11-ний хооронд:<br>-Боулинг<br>-Софтволейбол<br>-Корнхол<br>-Хонхот бөмбөгийн гэх мэт спортын 4 төрлөөр тэмцээнүүдийг зохион байгуулж нийт 130 иргэд оролцлоо. | 71 |
| Үндэсний болон спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ. | | | | | | | |
| Зорилт 10.Хүүхэд залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халааг бэлтгэх. | | | | | | | |
| 35. | Арга хэмжээ 10.1. Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн дундах "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, шигшээ тэмцээнд оролцуулна. | Байгууллагын төсөв | Дүүргийн тэмцээнд оролцох байгууллагын тоо, хамрагдах хүүхдийн тоо | 8<br>240 | 8<br>240 | "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн тэмцээн 04 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж, 7 цэцэрлэгийн 220 хүүхэд оролцсон. | 92 |
| | | | Шигшээ тэмцээнд хамрагдах хүүхдийн тоо | 30 | 30 | Шигшээ тэмцээн 138, 142 дугаар цэцэрлэгийн 30 хүүхэд хамрагдсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36. | Арга хэмжээ 10.2. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дундах "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж, шигшээ тэмцээнд оролцуулна. | Байгууллагын төсөв | Дүүргийн тэмцээнд оролцох байгууллагын тоо, хамрагдах хүүхдийн тоо | - | 1 тэмцээн зохион байгуулж, шигшээ тэмцээнд 16 хүүхэд оролцуулна. | Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дундах "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнд Ерөнхий боловсролын 2 сургуулийн 80 хүүхэд хамрагдсан. Шигшээ тэмцээнд ерөнхий боловсролын боловсрол сургуулийн баг 16 хүүхэдтэй амжилттай оролцсон. | 100 |
| Спортын сургалт- дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэнэ. | | | | | | | |
| Зорилт 11.Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчид, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах. | | | | | | | |
| 37. | Арга хэмжээ 11.1. Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн залгамж халааг сайжруулах, өрсөлдөх чадвар, амжилтыг дээшлүүлэх. | Дүүргийн төсөв 35.0 сая | Өсвөрийн шигшээ багийн тамирчдын өрсөлдөх чадварыг дээшлүүлж Монголын Хүүхдийн спортын VIII наадамд амжилтыг ахиулах | 2023 онд зохиогдсон Монголын Хүүхдийн спортын VII наадамд 10 төрлөөр оролцож 3 медаль хүртсэн. | Монголын Хүүхдийн спортын VIII наадамд 11 төрлөөр оролцож 4-өөс доошгүй медаль хүртэх | Монголын хүүхдийн спортын VIII наадмын шигшээ тэмцээний өвлийн спортын төрөлд шайбтай хоккейн 2 насны ангил 2алд баг тэргүүн байр эзэлжалтан медаль, зуны спортын төрлийн тэмцээнүүдэд спортын 16 төрлөөр 137тамирчид, 12 дасгалжуулагч оролцож,с агсан бөмбөгийн хөвгүүдийн баг хүрэл медаль, жу-до бөхийн төрөлд 2 хүрэл медаль, чөлөөт бөхийн төрөлд 2 хүрэл медальнийт алтан медаль-2, хүрэл медаль-5, бүгд- 7 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | 100 |
| 38. | Арга хэмжээ 11.2. Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлэх. | | Өсвөрийн шигшээ багийн спортын төрлийг 10-иар нэмэгдүүлнэ. | 7<br>145 | 10<br>145 | Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ баг спортын 7 төрлөөр 199 тамирчин хичээллэж байна.Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлэх зорилгоор дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй секц дугуйлан болон спортын холбоодуудтай хийх уулзалтын хөтөлбөр, төсөв, төлөвлөгөө | 71,5 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарган 2025.11.28-ны өдөр зохион байгуулсан. | |
| 39. | Арга хэмжээ 11.3. Өсвөрийн шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах. | | Өсвөрийн шигшээ багийн спортын төрөл, тамирчдын тоо | 7<br>145 | Өсвөрийн шигшээ багуудын тамирчдын сонгон шалгаруулалтыг шинэчлэн зохион байгуулж, Засаг даргаар батлуулан ажиллана. | Засаг даргын дэргэдэх 7 өсвөрийн шигшээ багуудад 117 хөвгүүд, 82 охид, нийт 199 тамирчдыг сонгон шалгаруулж шинэчлэн зохион байгуулж, Засаг даргаар батлуулан ажиллаж байна. | 100 |
| 40. | Арга хэмжээ 11.4. Улсын аварга шалгаруулах тэмцээнд баг, тамирчдаа бэлтгэлийг хангаж оролцуулах. | Байгууллагын төсвөөр 12.0 сая | УАШ-х өсвөр үе, насанд хүрэгчид, ахмадын тэмцээнд оролцох тоо | 2024 онд 21 тэмцээн, наадамд оролцсон. | Улсын аварга шалгаруулах 22-оос цөөнгүй тэмцээнд оролцуулна. | 2025 оны Улсын аварга шалгаруулах 46 тэмцээнд 698 тамирчид оролцож 89 медаль хүртэж, БТСХорооноос-6,648,400 төгрөг, Засаг даргын захирамжаар-23,700,000 төгрөг, ивээн тэтгэгчдээс-94,832,000 төгрөг, нийт-125,180,400 төгрөг зарцуулсан. | 100 |
| 41. | Арга хэмжээ 11.5. Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд баг, тамирчдаа бэлтгэлийг хангаж оролцуулах | төсвөөр 5.0 сая | Нийслэлийн тэмцээнд оролцох спортын төрлүүдийн тоо | 7 | 8 | Нийслэлийн аварга шалгаруулах 9 тэмцээнд 282 тамирчид оролцож, алтан медаль-4, мөнгө медаль-4, хүрэл медаль-4, нийт-12 медаль хүртэж, БТСХорооноос-5,971,200 төгрөг, Засаг даргын захирамжаар-6,070,000 төгрөг, ивээн тэтгэгч эцэг, эхчүүд, тамирчдаас-16,390,000 төгрөг, нийт-28,431,200 төгрөг зарцуулсан. | 100 |
| 42. | Арга хэмжээ 11.6. Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 3 насны ангиллаар зохион явуулах | Засаг даргын захирамжаар 120, сая | Монголын Хүүхдийн Спортын VIII наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээний спортын төрлийн | 2023 онд зохиогдсон Монголын хүүхдийн спортын VII наадмын дүүргийн аварга шалгаруулах | Монголын Хүүхдийн спортын VIII наадмын дүүргийн аварга шалгаруулах | Монголын хүүхдийн спортын VIII наадмын Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 12 төрлөөр зохион байгуулж дүүргийн 5 сургуулийн 609 сурагчид, тамирчид оролцож, Биеийн тамир,спортын хорооноос 4,355,000 төгрөг, Засаг даргын захирамжаар 12,000,000 төгрөг, нийт 16,355,000 төгрөг зарцуулсан | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэмцээний спортын төрлийн тоо | тэмцээнд спортын 10 төрөлд 76 багийн 512 хүүхэд оролцсон. | тэмцээнийг спортын 10-аас доошгүй төрлөөр зохион явуулах | | |
| 43. | Арга хэмжээ 11.7. Спортын төрлүүдийн секцүүдийг тогтмол хичээллүүлэх | | Хичээллэх секц дугуйлангийн төрөл, хамрагдах иргэд, залуусын тоо | 8 байгууллага, сургууль, клубын 23 секцэнд 807 хүүхэд залуучууд хичээллэсэн. | 24<br>850 | 2025 онд дүүргийн хэмжээнд спортын төрлүүдээр 40 секцүүдэд 33 багш-дасгалжуулагч ажиллаж, 1006 хүүхэд, залуучууд хичээллэж байна. | 100 |
| ДӨРӨВ. БУСАД: | | | | | | | |
| Зорилт 12.Байгууллагын нийтлэг чиг үүргийг хангуулах ажлын хүрээнд: | | | | | | | |
| 44. | Арга хэмжээ 12.1. Дээд газраас болон байгууллагуудаас ирсэн албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн албан бичиг, зөрчлийн тоог өмнөх оноос бууруулах | | Дээд газар, байгууллагуудаас ирсэн албан бичгийн тоо, зөрчлийн тоо | 2024 оны жилийн эцсийн байдлаар дээд шатны болон бусад байгууллага аж ахуй нэгжээс ирүүлсэн 247 албан бичгийг хүлээн авч, 362 албан бичгийг явуулан бүртгэл хөтөлсөн. Үүнээс 60 хариутай албан бичгийг заасан хугацаанд шийдвэрлэн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | Дээд газар, байгууллагуудаас ирсэн албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж , зөрчил гаргахгүй ажиллана. | 2025 оны 01-11 дүгээр сарын байдлаар дээд шатны болон бусад байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 272 албан бичгийг хүлээн авч 266 бичгийг шийдвэрлэсэн байна. 6 бичиг судалж байгаа төлөвтэй байна. 324 албан бичиг явуулж бүртгэл хөтөлсөн. 63 хариутай бичгийн заасан хугацаанд нь хүргүүлж ажилласан бөгөөд албан бичгийн зөрчил гаргаагүй. Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 99.1 хувьтай байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45. | Арга хэмжээ 12.2.<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тоог бууруулах<br>(Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 3.5.4) | | Иргэдийн өргөдөл, гомдлын тоо | Тайлангийн хугацаанд ажлаас чөлөөлөгдөх- 3, ажилд орох хүсэлт ирүүлсэн- 8, чөлөө хүссэн- 1, нийт 11 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллана. | Жилийн эцсийн байдлаар өргөдөл гомдлын мэдээг авч үзвэл: ажлаас чөлөөлөгдөх-1, ажилд орох хүсэлт ирүүлсэн-2, чөлөө хүссэн-1, жирэмсний болон амаржсаны чөлөө хүссэн-1, аавын 10 хоногийн цалинтай чөлөө хүссэн-1, нийт 6 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. | 100 |
| 46. | Арга хэмжээ 12.3.<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх<br>(Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 3.9.5) | | Авлигын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөсөн ажлын тоо | 2024 онд 8 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Хэрэгжилт- 91,2 хувьтай. | Төлөвлөгөөнд 8 ажил тусган батлуулж, биелэлтийг хангаж ажиллана. | Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/86 дугаар захирамжийн дагуу 3 зорилт 17 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан байгууллагын даргаар батлуулж хэрэгжилтийг хангаж, тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн. | 100 |
| 47. | Арга хэмжээ 12.4.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах(Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний | | Төлөвлөсөн ажлын тоо, хэрэгжилтийн хувиар | 2024 онд 3 зорилт 7 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжилт 80 хувьтай. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж хагас, бүтэн жилээр тайланг гаргаж хүргүүлнэ. | Жендэрийн тэгш байдлыг хангах арга хэмжээг 2 зорилт 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн. "Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого"-ын хэрэгжилтийг тооцон гаргаж Нийгмийн хөгжлийн хэлтэст хүргүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.1.5) | | | | | | |
| 48. | Арга хэмжээ 12.5. Жил бүр архивт хүлээн авсан баримтаар данс, бүртгэл үйлдэж байгууллагын баримт нягтлан шалгах комиссоор хэлэлцүүлж батлуулах | | Архивт хүлээн авсан баримтын тоо | 2023 онд 66 баримт материалыг архивт хүлээн авсан. | Жил бүр архивт хүлээн авсан баримтаар данс, бүртгэл үйлдэж байгууллагын баримт нягтлан шалгах комиссоор хэлэлцүүлж батлуулж ажиллана. | 2025 оны 01 дүгээр улиралд багтаан 2024 оны 74 баримт хүлээн авсан. | 100 |
| 49. | Арга хэмжээ 12.6. Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/452 дугаар захирамжийг хүрээнд захирамжлалын баримтаар цахим нөхөн бүрдүүлэлт хийх | | Нөхөн бүрдүүлэлт хийсэн баримтын тоо акт үйлдсэн эсэх | 2024 онд захирамжлалын баримтаар цахим нөхөн бүрдүүлэлт хийж акт үйлдсэн. | Нийслэлийн Засаг даргын захирамж аар цахим нөхөн бүрдүүлэлт хийж ажиллана. /актаар хүлээлцэх/ | 2024 оны захирамжлалын баримтаар А тушаал-86, Б тушаал-37 баримтыг программд шивж оруулан нөхөн бүрдүүлэлт хийж ,актаар хүлээлцсэн. | 100 |
| 50. | Арга хэмжээ 12.7. Байгууллагын хүүхэд, гэр бүлийн зөвлөлийн төлөвлөгөө төсвийг батлан хэрэгжилтийг хэнган ажиллах | Байгууллагын төсөв 1,500,000 | Төлөвлөгөө гарган биелэлтийг хангаж ажиллах ажлын тоо | 2024 онд төлөвлөгөөний дагуу 8 ажил хийгдсэн. | Төлөвлөгөөнд 8 ажил тусган батлуулж, биелэлтийг ханган ажиллана. | Байгууллагын хүүхэд, гэр бүлийн зөвлөлийн төлөвлөгөөг 2 зорилт 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар гаргаж ажилласан. 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэх хүрээнд байгууллагын 41 хүүхдэд гарын бэлэг гардуулж өгсөн. Нийт 1,500,000 төгрөг зарцуулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 51. | Арга хэмжээ 12.8. Байгууллагын залуучуудын хөгжлийн зөвлөлийн төлөвлөгөө төсвийг батлан хэрэгжилтийг хангаж ажиллах | төсөв 950.0000 | Төлөвлөгөө гарган биелэлтийг хангаж ажиллах ажлын тоо | 2024 онд төлөвлөгөөний дагуу 4 ажлыг хийж гүйцэтгэсэн. | Төлөвлөгөөнд 4 ажил тусган батлуулж, биелэлтийг хангаж ажиллана. | Биеийн тамир спорт хорооны даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/38 дугаар тушаалаар "Залуучуудын хөгжлийн зөвлөл-"ийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж 2025 онд нийт 4 ажил төлөвлөн 4 арга хэмжээг зохион байгуулж ажилласан. | 100 |
| 52. | Арга хэмжээ 12.9. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн төлөвлөгөө төсвийг батлуулан хэрэгжүүлэн ажиллах | Байгууллагын төсөв 350.000 төг | Төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжүүлэх ажлын тоо | 2024 онд төлөвлөгөөний дагуу 6 ажлыг хийж гүйцэтгэсэн. | Төлөвлөгөөнд 7 ажил тусган батлуулж, биелэлтийг хангаж ажиллана. | Байгууллагын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн төлөвлөгөөг 2 зорилт, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гаргаж ажилласан. Байгууллагын нийт 21 ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан. | 100 |
| 53. | Арга хэмжээ 12.10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн төлөвлөгөө төсвийг батлуулан хэрэгжүүлэн ажиллах (Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 3.1.4) | Байгууллагын төсөв 350.000 төг | Төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжүүлэх ажлын тоо | 2024 онд төлөвлөгөөний дагуу 7 ажлыг хийж гүйцэтгэсэн. | Төлөвлөгөөнд 7 ажил тусган батлуулж, биелэлтийг хангаж ажиллана. | Байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн төлөвлөгөөг 4 зорилт 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийн тайланг гаргаж ажилласан. Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг гаргасан. Дүүргийн замын цагдаагийн тасагтай хамтран Монгол Улсын замын хөдөлгөөний тухай хууль тогтоомжоор сургалт мэдээлэл нийт 12 албан хаагчдад өгч ажиллалаа. | 100 |
| 54 | Арга хэмжээ 12.11. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах | | Санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж, өр авлагагүй ажиллах | Санхүүгийн зөрчил гаргалгүй ажилласан. | Санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж, өр авлагагүй ажиллана. | Байгууллагын санхүүгийн мэдээ тайланг Dynamic санхүүгийн программ ашиглан гаргаж байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган байгууллагын даргаар хянуулж дүүргийн төрийн сангаар батлуулан ажиллаж байна. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| . | өр авлагагүй ажиллах | | | | | Тайлан мэдээг хугацаанд нь илгээсэн. Жилийн эцсийн байдлаар өр авлагагүй ажиллаж байна. | 100 |
| 55. | Арга хэмжээ 12.12. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах (Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 3.1.3) | | Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд оруулсан мэдээний тоо | 2024 оны 1-12 дугаар сарын хугацаанд нийт 169 мэдээ, мэдээллийг шилэн дансны цахим сайтад тавьж байршуулсан. 2 мэдээлэл хугацаа хоцроосон. | Шилэн дансны ил тод байдлын самбарыг тогтмол шинэчилж, мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд нь тавьж байршуулна. | 2025 онд 171 мэдээг шилэн дансанд байршуулахаар төлөвлөгдсөн. Үүнээс 1-11 дүгээр сарын байдлаар 148 мэдээ байршуулсан. 2 мэдээлэл хугацаа хоцроосон. Shilen.gov.mn site-д 3 дугаар улиралд шилэн дансны ил тод байдлыг үнэлсэн үнэлгээгээр 90,7 хувиар үнэлэгдсэн. | 100 |
| 56. | Арга хэмжээ 12.13. Байгууллагаас зохион явуулсан арга хэмжээ, тэмцээн уралдааны мэдээ мэдээллийг дүүргийн мэдээллийн хэрэгсэл. ТВ, цахим сүлжээнд тавьж сурталчлах | | Мэдээ мэдээллийг ТВ, цахим сүлжээнд тавьж сурталчлах тоо | 2024 оны 1-11 дүгээр сарын хугацаанд нийт 150 мэдээ, мэдээллийг шилэн дансны цахим сайтад оруулсан. Цахим сүлжээнд нийт 198 мэдээ мэдээллийг байршуулж ажилласан. | 55-иас доошгүй мэдээ тавьж ажиллана. | https://bnd.sport.gov.mn/ web-д Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчлэсэн найруулга сурталчлах аянтай холбоотойгоор цахимд байршуулан сурталчлан ажилласан. Биеийн тамир спортын хорооны face хуудсанд 77 мэдээлэл, 9 урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээлэл, 16 зар, 148 спорттой холбогдолтой мэдээлэл хуваалцаж, 6 reel, , БТСХ-ны youtube хуудсанд 2 контент нэвтрүүлэг оруулан<br>цахим сүлжээнд нийт 258 мэдээ, мэдээллийг байршуулж ажилласан. | 100 |
| 57. | Арга хэмжээ 12. 14. Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ, иргэдэд үйлчлэх соёл, угтах үйлчилгээг сайжруулах найрсаг харилцаа тухтай орчин бүрдүүлж ажиллах | Байгууллагын төсөв | Эрүүл аюулгүй ажлын байрны орчин бүрдүүлнэ. | Цэвэрлэгээ үйлчилгээний материалаар бүрэн хангаж ажилласан. | Ариутгал цэвэрлэгээг улирал бүр тогтмол чанартай хийнэ. | Байгууллагын өрөө тасалгаа болон заал танхимд өдөр бүр цэвэрлэгээ үйлчилгээ хийж байгаа бөгөөд байгууллагын үүдэнд жижүүрийн цагийн хуваарь гарган өдөр бүр 24 цагаар угтах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 58. | Арга хэмжээ 12. 15. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 3.7.2) | 200,000 төгрөг | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тарьж ургуулсан мод бутны суулгацын тоо | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2 удаа мод суулгацыг хуваарьт газарт тарьсан. Нийт 360,000 төгрөг зарцуулсан. | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хуваарьт газарт мод суулгац тарих ажлыг 2 удаа зохион байгуулна. | “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг 2 удаа зохион байгуулж байгууллагын ажилтаналбан , хаагчдаас 200,000 төгрөг цуглуулан хандивлаад байна. | 100 |
| 59. | Арга хэмжээ 12.16. Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх | 1.5 төгрөг | Байгууллагын харьяаллын ахмад настанд сар шинийн баяр, Ахмадын баяраар хүндэтгэл үзүүлнэ. | Сар шинийг тохиолдуулан байгууллагын 12 ахмад, Ахмадын баярын өдөр 14 ахмадуудыг хүлээн авсан. Нийт 1,301,400 төгрөг зарцуулсан. | Ахмадуудад 2 удаа хүндэтгэл үзүүлнэ. | Байгууллагын харьяалалтай ахмад настнуудад сар шинийн баяр, ахмадын баярын арга хэмжээнд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 1,070,000 төгрөг зарцуулсан. | 100 |
| 60. | Арга хэмжээ 12.17. Ажилтан, албан хаагчид нүүрсний хөнгөлөлт олгох | Байгууллагын 850.000 төгрөг | Ажилтан, албан хаагчдад нүүрсний хөнгөлөлт олгох | Байгууллагын 10 ажилтан, албан хаагчдад 640.000 төг нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн. | Гэр хороололд амьдардаг албан хаагчдад нүүрсний хөнгөлөлт олгоно. | Байгууллагын 9 ажилтан, албан хаагчдад 846,000 төгрөгийн нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн. | 100 |
| 61. | Арга хэмжээ 12.18. Байгууллагын ажлын байрны өрөө тасалгаануудад ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийх, | Байгууллагын төсөв | -Ариутгал халдваргүйтгэл хийсэн тоо -Цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн тоо | 2024 онд 1 удаа байгууллага дээр ариутгал хийлгэсэн. | Ариутгал халдваргүйтгэл тогтмолжуулна. | Байгууллагын ажлын байрны өрөө тасалгаануудад чийгтэй цэвэрлэгээг өдөр тутам, ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 удаа, байгууллага орчны 50м-ийн цэвэрлэгээг 10 удаа тус тус хийж гүйцэтгэсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын орчны 50 м-ийн бүсэд цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэх (Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээний 3.4.1) | | | | | | |
| Хэрэгжилтийн дундаж | | | | | | | 96,2 |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Арга хэмжээ 1.Монгол бичгийн сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлнэ. | Сургалтын ахисан шатны түвшинд хамрагдах | 2024 онд анхан шатны сургалтад бүрэн хамрагдсан. | Дунд шатны сургалтад хамрагдах | Дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн монгол бичгийн дунд шатны сургалтад бүрэн хамрагдсан. | 01.01<br>12.31 | 100% |
| 2 | Арга хэмжээ 2.Байгууллагын дотоод ажлыг 7 хоног болгоны 3 дахь өдөр зохион байгуулж, ажилтан албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад оролцоно. | Сургалт үйл ажилллагаанд оролцсон тоо | 2024 онд 12 удаа ажиллагсадын дунд сургалт, үйл ажиллагаа явуулсан. | 14 сургалт, бусад төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж ажиллана. | Байгууллагын хэмжээнд 7 хоног бүрийн лхагва гариг бүрт ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэн баг болгон хуваах нийт 15 сургалт, 16 тэмцээн тус тус зохион байгуулж ажилласан. | 01.01<br>12.31 | 100% |
| 3 | Арга хэмжээ 3.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамирын Улсын Хороо, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, | Сургалт үйл ажилллагаанд оролцсон тоо | 2024 онд 5 удаа сургалт зөвлөгөөнд хамрагдсан. | 3–аас дээш сургалтад бүрэн хамрагдана. | БТСХ-ны дарга Г.Сүхбаатар нь 2025.01.25-30-ны өдрүүдэд БНСУ-ын Бусан хотод зохион байгуулагдсан “Төрийн албан хаагчдыг чадавхижуулах” туршлага солилцох 5 өдрийн хөтөлбөр сургалтад хамрагдсан. | 01.01<br>12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Багануур дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах | | | | Биеийн тамир, спортын Улсын хорооноос зохион байгуулсан ХАСХОМ хэрхэн гаргах, мэдүүлэх талаарх сургалтад 2 удаа хамрагдаж, хуулийн хугацаанд нь ХАСХОМ мэдүүлсэн. Улсын хорооноос зохион байгуулсан цахим сургалтад 3, спортын шинэ төрөл болох тийбол бадминтоны сургалтад хамрагдсан. | | |
| Хэрэгжилтийн дундаж | | | | | | | 100% |

ТАЙЛАН ХЯНАСАН:
БИЕИЙН ТАМИР,СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БИЛЭГТ

2025 оны 12 дугаар сарын 15.

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

2025 оны 12 дугаар сарын 12.

ТАЙЛАГНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА Г.СҮХБААТАР

2025 оны 12 дугаар сарын 08